



## ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2018 оны 02 дугаар сарын 06

№ 01/08 ДУА-2018/33/СТА - ТЧЗ

Мандалговь хот

Г

Т

### Төлбөр барагдуулах тухай

Аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар албан томилолтыг **59,000.00 /Тавин есөн мянган/ төгрөгөөр илүү тооцож олгосон зөрчил илорлээ.**

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 1995 оны 218 дугаар тогтооюур батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 3.9-д /Албан томилолтоор ажилласан хоногийн тоог томилолтын үнэмлэхэд тэмдэглэсэн календарийн хоногоор гаргаж тооцно. Тээхэдээ явсан, буцаж ирсэн өдрийг нэг хоногт тооцно/ гэж заасныг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн толбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоломж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронуулж болгох саналыг холбогдох байгууллагас тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлж хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн толборийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор толборийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.3-т /Бусдад өгөх толбор тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон/ гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Илүү тооцож олгосон **59,000.00 /Тавин есөн мянган/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж 100080000955 дугаар дансанд 2018 оны 3 дугаар сарын 25-ны дотор төвлөрүүлэх.**
- Актын биелэлтийг 2018 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ируулэхийг Улсын бүртгэлийн хэлтсийн төсвийн шууд захирагч Ж.Өлзийжаргал, нягтлан бодогч Х.Гарам нарт хариуцуулав.

ТОГТООСОН<sup>1</sup>:  
АУДИТОР: *Оюун-Эрдэнэ*  
43/1144212  
ЗЮЛ0039 9056475

АКТЫГ  
ЗӨВШӨӨРСӨН:  
ДАРГА: *Ж.Өлзийжаргал*  
НЯГТЛАН БОДОГЧ: *Х.ГАРАМ*

<sup>1</sup>Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас төвьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хувацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дэгүү хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулхаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.